



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 5/89

Хэрлэн сум

Ажил хавсруулан гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 50 дугаар зүйлийн 50.2, 50.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхутаг сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Г.Батбаяр нь ажлаас чөлөөлөгдсөн тул 2017 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн тус сургуулийн багш Г.Батгэрэлээр сургуулийн захирлын үүргийг хавсруулан гүйцэтгүүлсүгэй.

2. Сургуулийн захирлын ажлыг хүлээлцэх комисс томилон ажиллуулахыг сумын Засаг дарга /Д.Байгалмаа/-д даалгасугай.

3. Захирлын ажлыг хавсран гүйцэтгэх Г.Батгэрэлд үндсэн цалингаас нь 40 хувиар тооцон нэмэгдэл хөлс олгохыг сургуулийн нягтлан бодогч /М.Цэнд-Аюуш/-д зөвшөөрсүгэй.

4. Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн ажлыг мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА